



Үндэсний виз мэдүүлэх

Их дээд сургууль, Их сургуулийн хэлний бэлтгэл, Коллежид сурах / Их сургуульд элсэх / Эрдэмтний зэрэг горилох виз (§16b und §17 AufenthG)

Үндсэн зааварчилгаа

- Гэрчилгээ, Диплом болон бусад баримт бичгийн эх хувийг өгнө. Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа эх хувийг буцаан олгоно.
- Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэхийн тулд Герман дахь Гадаадын Харьгат Иргэдийн газраас зөвшөөрөл авдаг. Тус газраас зөвшөөрөл ирсний дараа виз олгох боломжтой.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацаа нь 4 долоо хоног орчим байна. Зарим тохиолдолд илүү хугацаа орж болно.
- Визийн мэдүүлгийг өгөхдөө нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх явцад ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг уртасгах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх 4 долоо хоногийн дотор утсаар, И-Мэйлээр лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх тул виз мэдүүлэгч бүрт тухайлан хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн туслалцаа, үйлчилгээг ашиглах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.
- Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө.

Ерөнхий мэдээлэл

Германы их/дээд сургууль, Коллежид суралцах зөвшөөрөл авсан бол Германд их/дээд сургуульд сурах виз мэдүүлж болно. Германы их/дээд сургуулиас зөвшөөрөл авах нь цаг хугацаа шаарддаг учраас аль болох эртнээс энэ талаар хөөцөлдөхийг зөвлөж байна. Германд их/дээд сургуульд сурч байх хугацаандаа хөдөлмөр эрхэлж амьжиргаандаа нэмэрлэх боломжтой байдаг. Сургуулиа амжилттай дүүргэсний дараа Германд ажлын байр хайх боломжтой.

Германы их/дээд сургуульд докторын зэрэг хамгаалах эсвэл докторын хөтөлбөрт бүтэн цагаар хамрагдсан бол эрдэмтний зэрэг горилох виз мэдүүлж болно. Эрдэмтний зэрэг горилох нь хөдөлмөрийн гэрээний дагуу германы их/дээд сургууль эсвэл судалгааны байгууллагад хийгдэх бол судалгааны зорилгоор оршин суух виз мэдүүлнэ.



Бичиг баримтын жагсаалт

Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтуудыг эх хувиас гадна 1 хувь хуулбарын хамт өгнө.
Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө.

Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.

| | | |
|--|---|--------------------------|
| 1 | Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт 1 хувь ("VIDEX" маягт). | <input type="checkbox"/> |
| 2 | Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ. | |
| 3 | Хүчинтэй гадаад паспорт | |
| 4 | Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрний хуулбар | |
| 5 | Ямар учраас Германд их/дээд сургуульд сурах гэж байгаа талаар дэлгэрэнгүй тайлбар захидал (Motivationsschreiben). | |
| 6 | Өнөөг хүртэл эзэмшсэн боловсрол, мэргэжил болон эрхэлж байсан ажлаа алгасалгүй бүрэн оруулсан, хүснэгтчилсэн дэлгэрэнгүй намтар. | |
| 7 | Байгаа бол: Дээд Боловсролын Хяналтын Албаны (APS) гэрчилгээ эсвэл тодорхойлолт | |
| Зорилгоос хамаарч бүрдүүлэх бичиг баримт | | |
| Их/дээд сургуульд шууд элсэн сурах | | |
| 8.1 | <p>I. германы дээд сургуульд шууд элсэн сурах зөвшөөрөл (unbedingter Zulassungsbescheid)</p> <p>II. бакалавр эсвэл магистрын диплом</p> <p>III. боловсролын байгууллага элсэн сурах зөвшөөрөл олгох шийдвэр гаргахдаа герман хэлний мэдлэгийг шалгаагүй бол: Das Deutsche Sprachdiplom (DSD) эсвэл ALTE (Association of Language Testers in Europe) стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон сертификат. Үүнд “Хэлний түвшин тодорхойлох Европын нэгдсэн журам” (Gemeinsamer Europäischer Referenzrahmen für Sprachen)-ын дагуу B2 ба түүнээс дээш түвшний сертификаттай байх ёстой гэсэн нийтлэг журам үйлчилдэг.¹</p> <p>IV. Оюутан солилцоогоор суралцах бол мөн элсэн суралцах зөвшөөрөл (Zulassungsbescheid)</p> | |
| Дээд сургуулийн бэлтгэл буюу Коллежид сурах | | |
| 8.2 | <p>I. Коллежид шууд элсэн сурах зөвшөөрөл (unbedingter Zulassungsbescheid)</p> <p>II. Das Deutsche Sprachdiplom (DSD) эсвэл ALTE (Association of Language Testers in Europe) стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон сертификат. Үүнд “Хэлний түвшин тодорхойлох Европын нэгдсэн журам” (Gemeinsamer Europäischer Referenzrahmen für Sprachen)-ын дагуу B1 ба түүнээс дээш түвшний сертификаттай байх ёстой гэсэн нийтлэг журам үйлчилдэг.¹</p> | |



| Их сургуульд элсэх | | |
|--|--|--|
| 8.3 | <p>I. дээд сургуулийн орон тооны бүртгэлд орсон ЭСВЭЛ элсэлтийн өргөдлийг хүлээн авсан баталгаа ЭСВЭЛ uni-assist-аас ирсэн хариу ЭСВЭЛ коллежийн элсэлтийн шалгалтанд (Einladung zum Aufnahmetest) орох урилга</p> <p>II. Das Deutsche Sprachdiplom (DSD) эсвэл ALTE (Association of Language Testers in Europe) стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон сертификат. Үүнд “Хэлний түвшин тодорхойлох Европын нэгдсэн журам” (Gemeinsamer Europäischer Referenzrahmen für Sprachen)-ын дагуу B1 ба түүнээс дээш түвшний сертификаттай байх ёстой гэсэн нийтлэг журам байдаг.¹</p> | |
| Эрдэмтний зэрэг горилох | | |
| 8.4 | <p>I. Их сургуулийн эрдэмтний зэрэг горилох сургалтын зөвшөөрөл эсвэл докторантурын хөтөлбөр эх хувиараа</p> <p>II. Их сургуулийн диплом эх хувиараа</p> | |
| | ¹ Герман хэлний мэдлэгийн сертификат нь ALTE стандартын дагуу хэлний мэдлэгийг шалгах эрх бүхийг байгууллагаас олгосон сертификат байх ёстой. | |
| Амьжиргааны зардлыг санхүүжүүлэх баталгаа | | |
| <p>2023 оны 1 дүгээр сарын байдлаар Германд нэг сарын амьжиргааны доод хэмжээ 934 Евро бөгөөд нэг жилийн амьжиргааны баталгаа болох 11208 (арван нэгэн мянга хоёр зуун найм) Еврог визийн мэдүүлэгт өгнө. Их/дээд сургуульд элсэн орохоор төлөвлөж байгаа, хараахан сурах урилгаа аваагүй (Studienbewerber) бол германы Оршин Суух тухай хуулийн 17.2-ын дагуу виз мэдүүлж байгаа бол амьжиргааны нэг сарын баталгаа 947 Евро (нэг жилийн 11364 Евро) байна. Амьжиргааны баталгааг дараах баримтаар баталгаажуулна:</p> | | |
| 9.1 | <p>Германы аль нэг банкинд хязгаартай ашиглах данс (Sperrkonto) нээлгэх. Оршин суух визийн мэдүүлэгт хязгаартай ашиглах данс нээлгэж амьжиргааны баталгааг байршуулж болно. Хязгаартай данс нээхэд жуучилдаг байгууллагуудаас Та өөрөө сонгоно. Жуучлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын жагсаалтыг Та Холбооны Гадаад хэргийн яамны цахим хуудаснаас авч болно.</p> <p>Сурах виз мэдүүлэхээс өмнө хязгаартай ашиглах дансаа нээлгэж нэг жилийн амьжиргааны баталгааг байршуулсан байна. Дансанд байгаа нийт Евроны хэмжээ болон сард ашиглаж болох мөнгөн дүнг заасан банкны тодорхойлолтыг л ЭСЯ амьжиргааны баталгаа гэж үзнэ. Дансруугаа мөнгө шилжүүлсэн баримт амьжиргааны баталгаа болохгүй.</p> <p>ЭСВЭЛ</p> | |
| 9.2 | <p>Германы Оршин суух тухай хуулийн 66-68 зүйлд заасны дагуу албан ёсны батлан даалтын маягт (Verpflichtungserklärung). Гуравдагч этгээдээр гаргуулж болох энэ батлан даалтанд Германд оршин суух зорилгыг тодорхой заах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг батлан даагч өөрийн хотын Гадаадын иргэн харьяатын газраас, гадаадад амьдардаг бол Герман улсын төлөөлөгчийн газраас авах хэрэгтэй.</p> | |



| | | |
|-----|---|--|
| 9.3 | Байгаа бол: Амьжиргааны зардлыг хариуцах тэтгэлэг авсан баримт: тэтгэлэг олгох болсон тухай тодорхойлолт (Жишээ нь: Германы Эрдмийн Солилцооны Албанаас тэтгэлэг олгосон зөвшөөрөл - DAAD-Stipendienzusage) | |
|-----|---|--|

Эрүүл мэндийн даатгалын баримт

| | | |
|----|--|--|
| 10 | Германы хууль ёсны эрүүл мэндийн даатгалд (gesetzliche Krankenversicherung) хамрагдахыг хүсвэл оршин суух хаягийн бүртгэл болон сургуульдаа элсэн орсон байх шаардлагатай. Хичээл эхлэхээс өмнө Германд ирэх бол хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх шаардлагатай. Богино хугацааны аяллын эрүүл мэндийн даатгал нь Германд үргэлжлүүлэн удаан хугацаагаар оршин суух тохиолдолд нөхөн олговрын нөхцлүүд үйлчлэхгүй болж болох юм. „Incoming-Versicherungen“ төрлийн даатгал ч мөн адил урт хугацаагаар оршин суух тохиолдолд нөхөн төлбөрийн нөхцлүүд хүчин төгөлдөр бус болох магадлалтай. | |
|----|--|--|

Монголоос өөр орны иргэншилтэй виз мэдүүлэгч

| | | |
|----|---|--|
| 11 | Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл | |
|----|---|--|

Хураамж

| | | |
|----|--|--|
| 12 | Визийн хураамж 75 еврог монгол төгрөгөөр | |
|----|--|--|

Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал

Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх:

Гийм

Гүгй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу

Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл

Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Бичиг баримт дутуу мэдүүлэг өгөх нь визийг татгалзах шалтгаан гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно.

_____ газар, огноо, гарын үсэг